



**НИЙСЛЭЛИЙН
БАГАНУУР ҮЙЛДВЭРЛЭЛ, ТЕХНОЛОГИЙН ПАРК ОНӨААТҮГ
ДАРГЫН ТУШААЛ**

2020 оны 06 сарын 11 өдөр

Дугаар 1/21

Улаанбаатар хот

「Е-токен төхөөрөмжийг байгууллагын өмчид
хүлээн авч данс бүртгэлд бүртгэх тухай

Нийслэлийн Засаг даргын 2020 оны 03 дугаар сарын 05-ны өдрийн “Тоон гарын үсэг ашиглан, албан бичгийг цахим хэлбэрээр боловсруулах, байгууллага хооронд албан бичиг солилцох үйл ажиллагааг бүрэн цахимжуулах, холбогдох ажлыг зохион байгуулах тухай” үүрэг даалгавар, “Багануур үйлдвэрлэл, технологийн парк” Орон нутгийн өмчит төсөвт үйлдвэрийн газрын дүрмийн 5 дугаар зүйлийн 5.1.8 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Мэдээлэл технологийн газраас 2017 онд олгосон Е-токен төхөөрөмжийг байгууллагын өмчид хүлээн авч данс бүртгэлд бүртгэн, ашиглалт хамгаалалтыг хариуцан ажиллахыг Өмч хамгаалах байнгын зөвлөл /Д.Алтангэрэл/-д даалгасугай.

2. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Захиргааны алба /Б.Номинзул/-д даалгасугай.

ДАРГА



Ч.ЭЛБЭГСАЙХАН